



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/353

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор хяналт шалгалт хийх тусгай тоноглогдсон авто машин худалдан авах” ажлын нийлүүлэгчээр шалгарсан “Эм Жи Эм Глобал моторс” ХХК-тай 95,000,000 (ерэн таван сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т олгосугай.

2. Нийлүүлж буй тоног төхөөрөмжид чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т, тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.


3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эм Жи Эм Глобал моторс” ХХК-ийн захирал (Д.Мөнх-Учрал)-д даалгасугай.

4. Тус захирамж гарсантай холбогдуулан 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/245 дугаартай “Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай” захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй..

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 12-ны ний өдрийн
А/353 дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Бараа нийлүүлэх хугацаа	Хуанлийн 7 хоног	Д.Эрдэнэбилэг
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Очирсүрэн

--o00o--